



ОРХОН АЙМАГ  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, Уртбулаг баг,  
Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61033  
Утас: 7035 5590, Факс: (976)7035 2621  
Цахим шуудан: info@erdenet.mn

2020. 01. 07 № 03/36  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -г

МОНГОЛ УЛСЫН ЁС ЗҮЙН ХОРООНД

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль  
тогтоомжийн хэрэгжилтийн тайланг хүргүүлэв.

Хавсралт 8.. хуудастай

ДАРГА  Б.ГАНЗОРИГ



**2025 ОНЫ БАЙГУУЛЛАГЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНООС ХУУЛЬ ТОГТООМЖИЙН  
ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

2026.01.06

Эрдэнэт хот

**НЭГ. Товч танилцуулга**

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийн тайланд аймаг, сумын ИТХ-ын ажлын алба, аймаг, сумдын ЗДТГ, аймгийн Засаг даргын дэргэдэх удирдлагыг нь томилох эрх бүхий ХЗА, БОГ, БТСГ, ХААГ, ОНӨГ, ХХААГ, СХДААГ зэрэг нийт 13 байгууллагыг хамруулан ёс зүйн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах талаар зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлыг нэгтгэн тайлагнаж байна. Дээрх байгууллагуудад нийт 430 албан хаагч ажиллаж байгаагийн 41 нь улс төрийн, 183 нь төрийн захиргаа, 5 нь төрийн тусгай, 201 нь төрийн үйлчилгээний албан хаагч байна. Эдгээр байгууллагуудаас Жаргалант сумын ИТХ-ын ажлын алба нь 5 хүний бүрэлдэхүүнтэй тул Ёс зүйн дэд хороог байгуулах шаардлагагүй гэж үзэж томилох эрх бүхий албан тушаалтан Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна. Бусад 12 байгууллага тус бүрд Ёс зүйн дэд хороог байгууллагын албан хаагчдын саналыг үндэслэн байгуулж, нийт 44 албан хаагчийг байгууллагын даргын тушаалаар томилогдон хараат бусаар ажиллах нөхцөл, боломжоор хангагдан ажиллаж байна.

**ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар**

**2.1 Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт**

Тайлант хугацаанд төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ёс зүйн тухай хууль, тогтоомж, үндэсний хөтөлбөрийг төрийн байгууллагуудад ашиглаж буй и-оффис цахим системээр бүх албан хаагчдад хүргүүлсэн. Төрийн албан хаагчийн ёс зүйн зарчим, нийтлэг хэм хэмжээ, шаардлагыг сахиулах, хэвшүүлэх үйл ажиллагааг үе шаттайгаар зохион байгуулж, соён гэгээрүүлэх зэрэг сургалт нөлөөллийн ажлыг үе шаттай зохион байгуулан ажиллалаа. Үүнд: Дээрх байгууллагуудаас нийт “Байгууллагын соёл”, “Үе хоорондын ялгаа”, “Төрийн албан хаагчийн ёс зүй”, “Ажлын байрны ёс зүй”, “Байгууллага дахь хувь хүний хандлага”, “Стрессийн шинж тэмдэг, менежментийн арга хэрэгсэл”, Байгууллага дахь зөрчлийн сэтгэл зүй”, “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”, “Төрийн албаны үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага MNS 7068:2025” стандарт гэх мэт сэдвүүдээр нийт 37 удаагийн сургалт, “Соёлын хөтөлбөр”, “Ёс зүй, мэдлэг, хандлага” сэдэвт АХА тэмцээн, асуулт хариултын “QUIZ” тэмцээн, чөлөөт цагаараа өөрийгөө хөгжүүлэх нь зэрэг нөлөөллийн олон талт 36 удаагийн арга хэмжээг зохион байгуулж бүх албан хаагчдыг 2-12

удаагийн арга хэмжээнд хамруулснаар хувь ёс зүй, хандлага, сэтгэлгээ болон байгууллагын эерэг хандлага, соёлыг төлөвшүүлэхэд чухал ажлууд боллоо.

-Аймгийн ИТХ-ын ажлын алба, аймгийн ЗДТГ, Баян-Өндөр, Жаргалант сумын ЗДТГ, СХДААГ-аас байгууллагын цахим сайтад төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигаас ангид байх эерэг нөлөөлөх контентыг бүтээж, олон нийтэд болон байгууллагын фэйсбүүк группт түгээн ажилласан. <https://www.youtube.com/watch?v=wJp7NwEqEvw>, <https://www.youtube.com/watch?v=Yz8hQbiBIUk>

-СХДААГ- нь байгууллагын <https://sankhuu.orkhon.gov.mn/> сайтад “Сэтгэл ханамжийн судалгаа”-г тогтмол байршуулан, улирал бүр үр дүнг нэгтгэн дүн шинжилгээ хийж ажиллаж хэвшсэн.



- ХААГ-аас Сар бүрийн 3 дахь Даваа гарагт “Ёс зүйн зөвлөгөө өгөх өдөр” болгон зохион байгуулж хэвшсэнээр байгууллагын соёл, дотоод уур амьсгалд эерэг өөрчлөлтийг бий болгож албан хаагчид ажлаа урам зоригтой хийх нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна.

- Баян-Өндөр сумын ЗДТГ-аас ёс зүйн хэм хэмжээг хэвшүүлэх, албан хаагчдын ёс зүйн мэдлэг, хандлагыг дээшлүүлэх зорилгоор соён гэгээрүүлэх арга хэмжээг тогтмол зохион байгуулж, ёс зүйн зөрчил гаргаагүй, үлгэр жишээ ажилласан албан хаагчдыг урамшуулах ажлыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

- БТСГ-аас Үйлдвэрчний эвлэлийн хорооны гишүүдтэй хамтран “Ёс зүйн тухай хууль, тогтоомж, дүрэм, журмын мэдлэг, хандлага” сэдэвт АХА тэмцээнийг зохион байгуулж 3 багийн 18 албан хаагчийг оролцуулснаар ёс тухай тухай хууль, тогтоомжийн мэдлэгийг нь дээшлүүлсэн арга хэмжээ болсон байна. Мөн байгууллагын дотоод, гадаад орчны судалгааг хийсэн ба судалгаагаар нийт албан хаагчдын 90.3% нь харилцаа хандлага, ёс зүйн хувьд сайн гэж үнэлэгдсэн. Судалгааны дүнд үндэслэн дунд үндсэн бүлэгт чиглэсэн сургалт, нлөөллийн ажлыг 1 удаа зохион байгуулсан.

-Баян-Өндөр сумын ИТХ-ын ажлын албанаас хамт олны эерэг уур амьсгалыг бүрдүүлэх зорилгоор “Талархлын аян”-ыг 7 хоногийн хугацаатай зохион байгуулж хамгийн олон талархал авсан 1 албан хаагчийг дурсгалын зүйлээр шагнаж урамшуулсан.

Тайлант онд дээрх байгууллагуудад шинээр томилогдсон 6 албан хаагчдад Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, тогтоомжийн талаар танилцуулга мэдээллийг хийж, байгууллагын Ёс зүйн дэд хороодоос ёс зүйн талаар бэлтгэсэн гарын авлага, материалыг олгон ажилласан.

Дээрх байгууллагуудын албан хаагчдын Ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээг хийхэд нийт 34 ажлын байранд ёс зүйн зөрчилд өртөх эрсдэл маш өндөр, өндөр үнэлэгдсэн тус тус албан тушаалд ажиллаж буй 34 албан хаагчаар ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргуулж ажилласан.

## **2.2 Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал**

Төрийн байгууллагуудын удирдлагаас байгууллагынхаа соёлыг дээшлүүлэх, ёс зүйн талаар сургалт нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах, ёс зүйн дэд хороодын ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор нийт 80.6 сая төгрөгийг 2025 оны төсөвт тусган батлуулж хэрэгжилтийг хангуулан ажилласан. Тухайлбал: Удирдлагын академийн мэргэшүүлэх сертификаттай сургалтад 5 албан хаагчийг хамруулахад 975.0 мянган төгрөг, ёс зүйтэй албан хаагчийг шалгаруулан урамшуулахад 780.0 мянга, сургалт нөлөөллийн арга хэмжээнд 19.5 сая төгрөг, Ёс зүйн дэд хороодын гишүүдийн урамшуулалд нийт 59,4 сая төгрөгийг зарцуулсан байна. Мөн аймгийн ЗДТГ-аас төрийн албан хаагчийн ёс зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээг мэргэжлийн судалгааны байгууллага болох “Харилцааны гайхамшиг” ТББ-тай гэрээ байгуулан ажиллаж үнэлгээг хийлгэсэн байна. Мөн төрийн байгууллагуудын дэргэдэх Ёс зүйн дэд хороодыг хараат бусаар ажиллах дэмжлэг үзүүлж ажиллах төдийгүй тэднийг чадавхжуулах сургалтад хамруулах, сайн ажиллаж буй Ёс зүйн дэд хороодоос туршлага солилцуулах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Мөн байгууллагын Ёс зүйн дэд хороодын гишүүдийг чадавхжуулах “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам” сэдэвт сургалтад бүх байгууллагын дэд хороодын гишүүдийг хамруулах ажлыг зохион байгуулсан төдийгүй аймгийн ЗДТГ, СХДААГ-аас Ёс зүйн дэд хорооны 5 гишүүнийг “Удирдлагын академи”-ийн “Ёс зүй” анхан шатны мэргэшүүлэх сертификаттай сургалтад хамруулсан. Тайлант хугацаанд томилох эрх бүхий албан тушаалтантай холбоотой 1 гомдол ирснийг хуулийн хугацаанд шалгах ажиллагаа хийгдэж байна.

## **2.3 Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа**

Төрийн байгууллагуудын дэргэдэх Ёс зүйн дэд хороод нь холбогдох хууль тогтоомжид заасан чиг үүргийн хүрээнд иргэд, албан хаагчдаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авч, хянан шийдвэрлэж, дүгнэлт гарган ажиллаж байна. Тайлант онд 3 байгууллагад нийт 7 гомдол ирсэнийг хүлээн ав ёс зүйн цахим системд бүртгэж, гомдлын мөрөөр холбогдох хяналт шалгалтыг хийж ёс зүйн дэд хорооны дүгнэлт гарган ажилласнаар одоогийн байдлаар 8 гомдлыг дэд хорооны хурлаар хэлэлцэн 6 гомдолд холбогдох албан хаагч ёс зүйн зөрчил гаргасан тухай дүгнэлт гаргаснаар 2 албан хаагчийг уучлалт гуйхыг үүрэг болгосон шийдвэр гаргаж, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, хариуцлагын бүртгэлийн хуудсыг бөглөсөн бол 2 гомдол

хуулийн хугацаанд шалгагдаж байна. Мөн Ёс зүйн дэд хороодын ажлын төлөвлөгөө, тайланг тус тус ёс зүйн цахим системд оруулан ажилласан.

Ёс зүйн хорооны 2025 оны 06 дугаар тогтоолоор төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийх аргачилал батлагдсантай холбогдуулан Аймгийн ЗДТг-ын дэргэдэх Ёс зүйн дэд хорооноос 49 байгууллагын Ёс зүйн дэд хорооны дарга, нарийн бичгийн дарга нарт эрсдэлийн үнэлгээ хийх аргачиллын талаар сургалт зохион байгуулсан бол 16 байгууллагад эрсдэлийн үнэлгээ хийх аргачлалын талаар зөвлөгөө, мэдээллийг өгсөн.

Төрийн албан хаагчийн ёс зүйн зарчим, нийтлэг хэм хэмжээ, шаардлагыг сахиулах, хэвшүүлэх үйл ажиллагааг үе шаттайгаар зохион байгуулж, соён гэгээрүүлэх зэрэг сургалт нөлөөллийн ажлыг үе шаттай зохион байгуулан ажиллалаа. Үүнд: Дээрх байгууллагуудаас нийт “Байгууллагын соёл”, “Үе хоорондын ялгаа”, “Төрийн албан хаагчийн ёс зүй”, “Ажлын байрны ёс зүй”, “Байгууллага дахь хувь хүний хандлага”, “Стрессийн шинж тэмдэг, менежментийн арга хэрэгсэл”, Байгууллага дахь зөрчлийн сэтгэл зүй”, “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”, “Төрийн албаны үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага MNS 7068:2025” стандарт гэх мэт сэдвүүдээр нийт 37 удаагийн сургалт, “Соёлын хөтөлбөр”, “Ёс зүй, мэдлэг, хандлага” сэдэвт АХА тэмцээн, асуулт хариултын “QUIZ” тэмцээн, чөлөөт цагаараа өөрийгөө хөгжүүлэх нь зэрэг нөлөөллийн олон талт 36 удаагийн арга хэмжээг зохион байгуулж бүх албан хаагчдыг 2-12 удаагийн арга хэмжээнд хамруулснаар хувь ёс зүй, хандлага, сэтгэлгээ болон байгууллагын эерэг хандлага, соёлыг төлөвшүүлэхэд чухал ажлууд боллоо.



**Гарсан үр дүн, ололт амжилт**



**Бэрхшээл**

- Албаны ажилтан албан хаагчдын ажлын байрны тодорхойлолт, чиг үүргийн хүрээнд төрийн албан хаагчийн үйл ажиллагаанд баримтлах хууль тогтоомж, стандартын хэрэгжилт сайжирсан.

-Байгууллагын соёл, харилцаа хандлага дээшилж, багаар ажиллах, бие биенээ

-Төрийн хэмнэлтийн тухай хуулийг үндэслэн Аудитын газраас Ёс зүйн дэд хороонд ажиллаж буй албан хаагчдад олгосон урамшуулалд акт тавих, цаашид олгохгүй байх тухай зөвлөмж өгч байгаа төдийгүй 2025 оны 12 дугаар сард Сангийн яамнаас Ёс зүйн дэд хорооны гишүүдийн

|                                                                                                                                                                                                                                                                          |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <p>хүндлэх, иргэдэд хүнд суртал чирэгдэлгүй, хөнгөн шуурхай үйлчилгээ үзүүлж ажиллаж байна.</p> <p>-Албан хаагчдын ёс зүйн талаарх мэдлэг дээшилж, ёс зүйн эрсдэлээс хамгаалах чадамжтай болсон.</p> <p>- Албан хаагчдын сэтгэл ханамж, тогтвортой байдал нэмэгдсэн.</p> | <p>урамшуулал олгохгүй байх тухай чиглэлийг өгч, төсвийг татсанаас шалтгаалан зарим байгууллагууд ИҮ улиралын урамшууллыг олгох боломжгүй болсон байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 10.2 дахь хэсэгт заасны дагуу олгох эрх үүсэхгүй байгаа нь хууль эрх зүйн хувьд ойлгомжгүй байдлыг үүсгэж байна.</p> <p>- Зарим албан хаагч ёс зүйн асуудлыг зөвхөн сахилгын шийтгэлтэй холбон ойлгох хандлага бүрэн арилаагүй байна.</p> |
| <p><b>Санал</b></p> <p>Төрийн албан хаагчийн Ёс зүйн тухай хуульд заасны дагуу Ёс зүйн дэд хороодод ажиллаж буй албан хаагчдад олгох урамшууллыг олгуулах талаар холбогдох байгууллагуудтай харилцан ойлголцолд хүрч шийдвэрлүүлэх саналтай байна.</p>                   |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |

**Шалгах хэсэг:**

- ✓ Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээ хийсэн эсэх,
- ✓ Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх,
- ✓ Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх,

**БАТАЛГААЖУУЛАЛТ:**

ОРХОН АЙМГИЙН ЗДТГ-ЫН ДАРГА

Б.ГАНЗОРИГ

АЙМГИЙН ЗДТГ-ЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ДАРГА

О.САНЖМЯТАВ

АЙМГИЙН ЗДТГ-ЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Б.ЦЭРЭННАДМИД

**БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР  
ҮЗҮҮЛЭЛТ /Орхон аймгийн ЗДТГ/**

2026.01.06

Эрдэнэт хот

| №                                 | Үзүүлэлт                                                                                                             | Шалгуур үзүүлэлт                                                                                                                                                           | Авбал зохих оноо                                                                            | Оноо[1]    | Хувийн жин[2] |    |
|-----------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------|------------|---------------|----|
| 1                                 | 2                                                                                                                    | 3                                                                                                                                                                          | 4                                                                                           | 5          | 6             |    |
| 1                                 | Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[3] (ҮХХ) | Үйл ажиллагааны төлөвлөгөөг шалгуур үзүүлэлттэй нийцүүлэн баталсан эсэх[4]                                                                                                 | 1                                                                                           | 1          | 10%           |    |
| 2                                 |                                                                                                                      | Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэх [5]                                                                                              | 1                                                                                           | 1          | 10%           |    |
| 3                                 |                                                                                                                      | Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[3] (ҮХХ)                                                       | Ёс зүйн сургалтыг 2-оос доошгүй удаа батлагдсан агуулгын хүрээнд зохион байгуулсан эсэх [6] | 0.5        | 0.5           | 5% |
|                                   |                                                                                                                      |                                                                                                                                                                            | Соён, гэгээрүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулсан байдал[7]                               | 0.5        | 0.5           | 5% |
|                                   |                                                                                                                      |                                                                                                                                                                            | Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргасан байдал[8]                                              | 0.5        | 0.5           | 5% |
|                                   |                                                                                                                      |                                                                                                                                                                            | Ёс зүйн зөрчлийн хариуцлагын бүртгэлийн маягт бөглөсөн байдал[9]                            | 0.5        | 0.5           | 5% |
| <b>Хэсгийн оноо</b>               |                                                                                                                      |                                                                                                                                                                            | <b>4</b>                                                                                    | <b>4</b>   | <b>40%</b>    |    |
| 4                                 | Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал (ЁЗМ)                                                            | Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан эсэх [10] ( <i>гарсан дүгнэлтийн хувийн жингээр тооцох бөгөөд гомдол ирээгүй бол 1 оноо</i> )                     | 1                                                                                           | 1          | 10.0%         |    |
| 5                                 |                                                                                                                      | Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулсан байдал[11]                             | 1                                                                                           | 1          | 10%           |    |
| 6                                 |                                                                                                                      | Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал[12]                                                                    | 1                                                                                           | 0.5        | 5%            |    |
| <b>Хэсгийн оноо</b>               |                                                                                                                      |                                                                                                                                                                            | <b>3</b>                                                                                    | <b>2.5</b> | <b>25.0%</b>  |    |
| 7                                 | Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа (ЁЗДХ)                                                                             | Дэд хорооны бүрэлдэхүүн хөдөлгөөнийг бүртгэсэн байдал[13]                                                                                                                  | 1                                                                                           | 1          | 10.0%         |    |
| 8                                 |                                                                                                                      | Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байдал [14] ( <i>Гомдол ирээгүй бол 1 оноо авна, нийт ирүүлсэн өргөдөл, гомдлын хувийн жингээр тооцно</i> ) | 1                                                                                           | 1          | 10%           |    |
| 9                                 |                                                                                                                      | Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем дэх дүгнэлт, шийдвэрийг бүртгэж, тайлагнасан байдал                                                                          | 1                                                                                           | 1          | 100%          |    |
| <b>Хэсгийн оноо</b>               |                                                                                                                      |                                                                                                                                                                            | <b>3</b>                                                                                    | <b>2.5</b> | <b>30%</b>    |    |
| <b>Үнэлгээний нийт оноо, хувь</b> |                                                                                                                      |                                                                                                                                                                            | <b>10</b>                                                                                   | <b>9</b>   | <b>95.0%</b>  |    |

Тайлбар: Аймгийн Засаг даргын томилох эрх бүхий 7 агентлаг, Аймгийн ИТХ, ЗДТГ, Баян-Өндөр, Жаргалант сумын ИТХ, ЗДТГ- нийт 13 байгууллагыг хамруулан ёс зүй, сахилга хариуцлагын шалгуур үзүүлэлтээр үнэлсэн.

ҮНЭЛГЭЭГ НЭГТГЭСЭН. АЙМГИЙН ЗДТГ-ЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА  Б.ЦЭРЭННАДМИД

БАТЛАВ.

ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ДАРГА

О.САНЖМЯТАВ

АЙМГИЙН ЗДТГ-ЫН ДЭРГЭДЭХ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНД ХИЙХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2025.01.19

Эрдэнэт хот

| № | Хийх ажил                                                                                                                                                                                                                                                                                      | Шалгуур үзүүлэлт                                                                                                                 | Суурь түвшин /2024 он/ | Хүрэх түвшин /2025он/ | Хугацаа             | Хариуцах албан тушаалтан                                                              |
|---|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------|-----------------------|---------------------|---------------------------------------------------------------------------------------|
| 1 | Байгууллагын албан хаагчдад Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийг сурталчлан таниулах, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, тогтоомж, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах. | Зохион байгуулсан<br>-Сургалт<br>-Нөлөөллийн арга хэмжээ<br>- Сургалт,<br>нөлөөллийн арга хэмжээнд хамрагдсан албан хаагчийн тоо | 2<br>1<br><br>68       | 2<br>1<br><br>69      | II, III, IV улиралд | Дэд хороо<br>О.Санжмятав<br>М.Бямбадорж<br>Б.Цэрэннадмид<br>Р.Галбаатар<br>Л.Дуламжав |
| 2 | Байгууллагад шинээр ажилд орсон ажилтанд чиглүүлэх сургалтыг ТЗУХ-тэй хамтран зохион байгуулах.                                                                                                                                                                                                | Шинээр томилогдсон албан хаагчдын сургалтад хамрагдалтын хувь                                                                    | 89.0%                  | 100%                  | Тухай бүрд          | Дэд хорооны гишүүн<br>О.Санжмятав<br>Б.Цэрэннадмид                                    |
| 3 | Төрийн албан хаагчдаас ёс зүйн талаарх хууль, тогтоомжийн талаар санал асуулга авах                                                                                                                                                                                                            | Санал асуулгад хамрагдсан албан хаагчийн тоо                                                                                     | -                      | 74                    | I улиралд           | Нарийн бичгийн дарга<br>Б.Цэрэннадмид<br>Гишүүн                                       |
| 4 | Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн талаар гаргасан гомдол, мэдээллийг хүлээн авч цахим санд бүртгэх.                                                                                                                                                                                       | Ирсэн өргөдөл гомдлын бүртгэлийн хувь                                                                                            | 100%                   | 100%                  | Тухай бүрд          | Дэд хорооны нарийн бичгийн дарга<br>Б.Цэрэннадмид                                     |

|    |                                                                                                                                                                        |                                                         |                                     |                                           |                    |                                                                            |
|----|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------|-------------------------------------|-------------------------------------------|--------------------|----------------------------------------------------------------------------|
|    |                                                                                                                                                                        |                                                         |                                     |                                           |                    | М.Бямбадорж                                                                |
| 5  | Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн талаар гаргасан гомдол, мэдээллийг хянан шалгаж, дэд хорооны хурлаар хэлэлцэн шийдвэрлэх.                                       | Ирсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хувь               | 100%                                | 100%                                      | Тухай бүрд         | Гомдол, мэдээлэл хуваарилагдсан гишүүн, Нарийн бичгийн дарга Б.Цэрэннадмид |
| 6  | Төрийн албан хаагчийн Ёс зүйн асуудлаар видео хичээл бэлтгэх                                                                                                           | Бэлтгэсэн хичээлийн тоо                                 | -                                   | 1                                         | I улиралд          | Гишүүн М.Бямбадорж Р.Галбаатар                                             |
| 7  | Ёс зүйн зөрчил, түүний шалтгаан, эрсдэлийг тодорхойлон, дүн шинжилгээ хийж холбогдох байгууллага, албан тушаалтанд зөвлөмж хүргүүлэх.                                  | Өргөдөл, гомдол мэдээлэл ирсэн тухай бүрд               | -                                   | Өргөдөл, гомдол мэдээлэл ирсэн тухай бүрд | Тухай бүрд         | Гишүүн М.Бямбадорж П.Энхжаргал О.Санжмятав                                 |
| 8  | Гомдол мэдээллийг хянан шалгаж шийдвэрлэхэд хамаарах нотлох баримт, холбогдох шийдвэрийг цахим санд оруулах, хувийн хэрэг бүрдүүлж байгууллагын архивт хүлээлгэн өгөх. | Ирсэн өргөдөл гомдлын цахим санд оруулсан байдал /хувь/ | 100%                                | 100%                                      | Тухай бүрд         | Нарийн бичгийн дарга Б.Цэрэннадмид                                         |
| 9  | Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбогдох тайлан мэдээг гаргах.                                                                                                | Хугацаанд нь тайлан мэдээг гаргасан байх                | Хугацаанд нь тайлан мэдээг гаргасан | Хугацаанд нь тайлан мэдээг гаргах         | Хагас бүтэн жилээр | Нарийн бичгийн дарга Б.Цэрэннадмид                                         |
| 10 | Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны тайланг гарган Ёс зүйн хороонд хүргүүлэх.                                                                                          |                                                         |                                     |                                           | Хагас бүтэн жилээр | Нарийн бичгийн дарга Б.Цэрэннадмид                                         |

ТӨЛӨВЛӨГӨӨ ГАРГАСАН.НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



Б.ЦЭРЭННАДМИД